



**БУЛГАН АЙМГИЙН  
УС, ЦАГ УУР, ОРЧНЫ  
ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВ**

Залуус хороолол 7-700, Булган баг, Булган сум,  
Булган аймаг, 63086, Утас: 7034-2360

Цахим шуудан: bulgan\_tsaguur@yahoo.com

Цахим хуудас: bulgan.tsag-agaar.gov.mn

2025.06.20 № 01194  
Танай 2025.06.18-ны № 09/949 -г

**АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН  
ГАЗРЫН ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭ,  
ДОТООД АУДИТЫН ХЭЛТЭСТ**

Ус цаг уур орчны шинжилгээний төвийн 2025 оны эхний хагас жилийн үйл ажиллагаанд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийн тайланг хавсралтаар хүргүүлэв.

Хавсралт 7 хуудастай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР  
ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ, МЭДЭЭЛЭЛ  
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ  
ХЭЛТСИЙН ДАРГА

Б.НАНДИНБАТ



/D. тоот/ 94 2025.06.20

202500156

УС ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ТӨВИЙН ДАРГЫН ДЭРГЭДЭХ  
ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

№ 06

2025.06.23

Зөвлөлийн гишүүдийн хурлыг 2025 оны 06 дугаар сарын 23-ний өдрийн 14 цагт төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нандинбатын өрөөнд ЦУОТХ-ийн дарга Б.Буяннэмэх, МҮХ-ийн технологич инженер Ж.Отгонжаргал, ЗСААХ-ийн ахлах нягтлан бодогч А.Оюунтуяа, ХААЦУ-н инженер Э.Сарантуяа, Уур амьсгалын ерөнхий технологич инженер Д.Энхээ, Усны инженер И. Гансувд, хүний нөөц, бичиг хэргийн ажилтан Т. Түмэнжаргал нарын бүрэлдэхүүнтэйгээр хуралдав.

Хэлэлцэх асуудал:

1.Засгийн газрын тогтоол шийдвэрийн хэрэгжилт

Хэлэлцэх асуудлуудтай холбогдуулан төвийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч, мэдээлэл үйлчилгээний хэлтсийн дарга Б.Нандинбат танилцуулга хийв.

1. Монгол улсын Монгол хэлний тухай хуулийн 20.1.1 дэх заалтын дагуу 2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн төрийн захиргааны болон нутгийн өөрөө удирдах байгууллагууд төрийн албан хэрэг хөтлөх ажлыг хос бичгээр явуулах шаардлагатай болсон. Үүнтэй холбогдуулан хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангах, төрийн албан хаагчийн үндэсний бичгээр албан хэрэг хөтлөх ур чадвар, мэдлэгийг нэмэгдүүлэх зорилгоор 2025 оны 03 дугаар сарын 24-ний өдрөөс эхлэн нэг сарын хугацаанд нийт албан хаагчдыг хамруулан Монгол хэл, бичгийн 2 багштай хамтран анхан болон дунд шатанд хувааж 10 цагийн сургалтыг зохион байгуулж ажиллаа. Энэхүү ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хянах зорилгоор 5 гишүүнтэй ажлын хэсэг байгуулж, байгууллагын албан хаагчдыг монгол бичгийн сургалтад бүрэн хамруулах, "Монгол бичгийн цахим гарын авлага"-ыг таниулж, хэрэглээнд нэвтрүүлэх, монгол бичгээр хөтлөн явуулах ур чадварыг тусгасан төлөвлөгөө гарган ажилласан бөгөөд төлөвлөгөөний хэрэгжилт 100%-тай гэж дүгнэж байна.

Байгууллагын шийдвэр, албан бичгийг дүрэм, журам, заавар, стандартын дагуу хос бичгээр хөтлөх ажлыг эхлүүлэхээр аймгийн ААХХХУБайцаагчид Монгол бичгийн бланк хүргүүлэн шалгуулж хэвлэх үйлдвэрт хүргүүлсэн хэвлэгдэж гарч ирээгүй байна.

Ажилтан албан хаагчид баримт бичгийн хавтасны товъёогыг монгол бичгээр хослуулан мөн байгууллагын гадна болон өрөө тасалгааны хаяг, монгол бичгээр бичиж байршуулан ажиллаж байна.

Мөн албан хаагчдын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд монгол бичгийг сурах, түвшингээ ахиулах, хэрэглээг нэмэгдүүлэх чиглэлийг тусган ажиллаа.

2.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу төлөвлөн тайлагнаж ажиллаж байна.

3.Байгаль, орчин, аялал жуулчлалын сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд, Сангийн сайдын хамтарсан 2023 оны А/421, А/115, А170 тушаалын 2 дугаар хавсралтыг үндэслэн албан хаагчид ур чадварын нэмэгдэл олгох шалгуур үзүүлэлтээр журмын дагуу олгож байна.

4. "Агаарын чанарыг сайжруулах бүсийг шинэчлэн тогтоож аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулан цаашид хийгдэх ажлын талаар хөтөлбөр төлөвлөгөөг шинэчлэгдсэн агаарын чанарын стандартын дагуу боловсруулах ажил хийгдэж байна.

5.Байгууллагын үйл ажиллагаанд тоон гарын үсгийг хэрэглэн ашиглаж байна. Хэрэгжилт 70%-тай байна.

6. Халдварт болон халдварт бус өвчнөөс урьдчилан сэргийлэх эрт илрүүлэх үзлэг, шинжилгээ, оношилгоонд байгууллагын бүх ажилтан, албан хаагчдыг 2022, 2024 онд 100% хамрагдсан. 2026 онд давтан хамрагдана.

7.Байгууллагын баримт бичгийг <https://erp.e-mongolia.mn/> дундын солилцооны системүүдийг ашиглаж байна.

8.Эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд засаг, захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, хуулийн этгээдийг өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан 2024 оны 12 дугаар сарын 30-ний өдрөөс тус төвийн мэргэжлийн ангийн бэлтгэл бэлэн байдлыг хангуулан ажиллуулсан, мөн 0-5 хүртлэх насны хүүхэдтэй эцэг, эхчүүдийг хуулийн дагуу гэрээсээ онлайнаар ажиллуулахаар болсон ч тухайн үед ажиллах ажилчид байгаагүй, одоо хэвийн горимд шилжэн ажиллаж байна.

9. "2025 онд улсын хэмжээнд Агаарын бохирдолыг хянах байнгын ажиллагаатай автомат станцыг БНСУ-ын буцалтгүй тусламжаар шинээр 21 аймагт суурилуулах ажил хийгдэж байгаа бөгөөд манай аймагт энэ сарын 26-д суурилуулна. Энэ автомат станц тавигдснаар агаарын бохирдолыг 5 үзүүлэлтээр минут тутамд тодорхойлох, хяналт тавих боломжоор хангагдах юм.

2025 оны эхний хагас жилийн хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт 97,69%-тай байна.

Зөвлөлийн гишүүд санал нэгтэй 2025 оны эхний хагас жилийн хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийн үйл ажиллагаанд хийсэн ажлууд хэвийн явагдаж байна гэж дүгнэлээ.

---

Шийдвэрлэсэн нь:

Дээрх хяналт-шинжилгээ, үнэлгээний хэрэгжилтийн тайланг холбогдох газарт нь хүргүүлэхээр болов.

Хэлэлцэх асуудал дууссан тул хурлыг 15 цагт дуусгав.

ХУРАЛ УДИРДСАН:

УЦУОШТ-ИЙН ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ,  
МЭДЭЭЛЭЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХЭЛТСИЙН ДАРГА  Б.НАНДИНБАТ

ТЭМДЭГЛЭЛ ХӨТӨЛСӨН:

ХҮНИЙ НӨӨЦ, БИЧИГ ХЭРГИЙН АЖИЛТАН  Т.ТҮМЭНЖАРГАЛ

